

СОЁЛЫН БИЕТ БУС ӨВИЙН КОНТЕНТ БҮТЭЭХ ТӨСЛИЙН САНААНЫ УРАЛДААН

Нэг. Нийтлэг үндэслэл:

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын бичиг “Алсын хараа 2050” – ийн Зорилго 1-т “эх хэл, эх түүх, өв соёлыг нийт хүн амд төлөвшүүлж, үндэсний ижилсэл-ондоошлын гүн ухамсар, дархлаатай үндэстэн-улс байгуулахад тулгуур болохуйц нэгдмэл үнэт зүйлсийг цогцлооно”. Түүнчлэн 1.2.11.-т “Соёлын үйлдвэрлэл, соёлын бүтээлч аялал жуулчлалыг Монголын нүүдлийн соёлын онцлогт тохируулан нутагшуулж, үндэсний загвартай болох, үндэсний үнэт зүйлийг бүтээх, хадгалах, хамгаалах, аялал жуулчлалын эргэлтэд оруулахад зориулсан мэдээллийн систем, цахим технологи нэвтрүүлнэ” хэмээн тусгасан. Мөн Монгол Улсын Соёлын тухай хууль, Соёлын өвийг хамгаалах тухай хууль болон бусад холбогдох хуульд заасны дагуу СББӨ-ийг сурталчилан таниулах, алдаршуулах ажлын хүрээнд “СББӨ ба цахим контент” уралдааныг БНСУ дах ЮНЕСКО-гийн II зэрэглэлийн Соёлын Биет Бус Өвийн Мэдээлэл Солилцооны Ази-Номхон Далайн Төвийн ICHLinks төслийн хүрээнд Соёлын өвийн үндэсний төв, Соёлын өвийн сүлжээ, харилцаа холбооны зөвлөл ТББ хамтран зохион байгуулж байна.

Хоёр. Зорилго:


- ❖ СББӨ-ийг олон нийтэд цахим контентоор дамжуулан таниулан сурталчлах, мэдлэг ойлголт түгээх
- ❖ СББӨ-ийн цахим контент бүтээгчдийг олж илрүүлэх, хөгжүүлэх, бүтээлч санааг дэмжих
- ❖ Монгол СББӨ-ийн үнэ цэн болон цахим контент бүтээгчдийг Ази-Номхон далайн бүс нутгийн СББӨ-ийн платформ дээр алдаршуулан сурталчлах

Гурав. Хамрах хүрээ:

Хамт олон (баг), хувь уран бүтээлч, оюутан залуус хэн бүхэнд нээлттэй.

Дөрөв. Сэдэв

ЮНЕСКО-гийн 2003 оны “Соёлын биет бус өвийг хадгалах тухай” конвенци, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн “Бүртгэл шигэчлэн батлах тухай” А/759 дүгээр Тушаалын нэгдүгээр хавсралтаар батласан “Монгол Улсын соёлын биет бус өвийн Төлөөллийн үндэсний бүртгэл”, хоёрдугаар хавсралтаар баталсан “Яаралтай



хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн үндэсний бүртгэл”-д хамаарах дараах 7 ай савыг хамруулна. Үүнд:

1. Эх хэл, аман уламжлал, илэрхийллүүд.
2. Ардын язгуур урлаг
3. Уламжлалт баяр наадам, зан үйл, ёс, тоглоом, наадгай, уриа дуудлага
4. Байгалийн болон сав шим ертөнцийн тухай мэдлэг, зан үйл
5. Уламжлалт арга ухаан
6. Мал маллах арга ухаан
7. Уламжлалт гар урлал

(Тушаалын хавсралтыг Соёлын өвийн үндэсний төвийн цахим хуудаснаас татаж авна уу)

Тав. Хугацаа:


1-р үе шат:

- ❖ 2022 оны 9-р сарын 23-ны өдрөөс 10-р сарын 10-ны өдөр төслийг хүлээн авна.
- ❖ 2022 оны 10-р сарын 15-нд урьдчилсан үнэлгээг дотоодын шүүгчид гаргана.
- ❖ 2022 оны 10-р сарын 20-нд олон улсын болон дотоодын шүүгчдийн баг эцсийн үнэлгээг нэгтгэн гаргана.
- ❖ 2022 оны 10-р сарын 25-ны өдөр шилдэг төслийн санаануудыг шалгаруулж, дүнг танилцуулна.
- ❖ 2022 оны 11-р сарын 01-07-ны өдрүүдэд шалгарсан төслийн санаачлагчидад шагнал гардуулах, үзэсгэлэн дэглэж олон нийтэд танилцуулна.

2-р үе шат:

2022 оны 11-12 сар

- ❖ 1-р үе шатнаас шалгарсан шилдэг 5 төслийг БНСУ дах ЮНЕСКО-гийн II зэрэглэлийн Соёлын Биет Бус Өвийн Мэдээлэл Солилцооны Ази-Номхон Далайн Төвийн ICHLinks төслийн эцсийн шалгаруулалтад оролцох эрх олгоно.
- ❖ ICHLinks платформ дээр цахим үзэсгэлэнг байршуулна.
- ❖ Эцсийн шатанд шалгарсан контент бүтээгчидэд (5 хүртэлх) 2023 онд “СББӨ-ийн цахим контент хамтран бүтээх” эрх болон санхүүгийн дэмжлэг олгон хамтран ажиллана.




Зургаа. Тавигдах шаардлага:

- **Гэрэл зураг, постер, гар зураг**
 - ❖ Формат: JPEG, PNG, GIF
 - ❖ Image Pixel: 960 X 540 ~ 1920 X 1080
 - ❖ File Name: name of the photo_content title_content category_contributor(country)_year
- **Видео**
 - ❖ Формат: MP4 эсвэл Youtube Video URL
 - ❖ Display Resolution (Хамгийн багадаа): 1920x1080
 - ❖ File Name: name of the video_content title_content type_contributor(country)
- **Аудио**
 - ❖ Формат: MP3, WAV
 - ❖ File Name: name of the audio_content title_content type_contributor(country)
- Төслийн агуулга, ач холбогдол, дүрслэл, хар зураглал
- Төсөлд холбогдолтой өөрийн бүтээл болох гэрэл зураг, видео бичлэг, өгүүлэмжийг хавсаргах
- Төслийг бүтээхэд шаардагдах санхүүгийн төсвийг хавсаргах (8.000-30.000 ам.долларт багтаах)
- Холбогдох гэрэл зураг, видео бичлэгийг сурталчилгааны зорилгоор ашиглах зөвшөөрлийг хавсаргах
- Бүтээл нь төслийн уралдааны чиглэл болох доор дурдсан сэдвийн хүрээнд байх.
- Бүтээлд сэдвийн хүрээнд нэр олгосон байх.
- Төслийн материалыг англи, монгол хэл дээр хүлээн авна.

Долоо. Шалгаруулалт:

СББӨ болон мэдээлэл технолог, найруулага, гэрэл зураг зэрэг мэргэжлийн шинжээчдээс бүрдсэн дотоодын болон олон улсын хөндлөнгийн шүүгчдийн баг шалгаруулна.



Найм. Байр:

I байр (нэг) – 2’000’000₮

II байр (хоёр) – 1’500’000₮ тус бүр

III байр (хоёр) – 800’000₮ тус бүр

Тусгай байр (тав) – 300’000₮ тус бүр.

Ес. Уралдаанд оролцох бүтээлийг дараах имэйл-ээр хүлээн авна:

И-мэйл: contact@culturalheritagecouncil.mn

Арав. Холбоо барих:

Уралдаантай холбоотой дэлгэрэнгүй мэдээллийг ажлын цагаар 99055643 (Алтансүх) дугаараар холбогдож авна уу.